



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/43/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: О.Алтансүх

Утас: 99077045 Цахим хаяг: Altansukho52@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН СУМ Т
ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГА
Н.БАЯРСАЙХАН ТАНАА

2020.02.13 № 1/71
танай _____ -ны № _____ -т
Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын

005020024

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Н.Баярсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.08-наас 2020.02.10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын гэрээт аудитор О.Алтансүх хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.24-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Ойн баялгийн нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх,” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги нь Ойн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Ойн тухайн хууль болон холбогдох тогтоол, дүрэм, журам

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн ACOLOUS болон цалингийн Payroll программ” программ хангамж ашигладаг байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 34 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 30 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг " дунд," гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 106003,5 мянган төгрөгөөс тооцон 2120,0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 712567,6 байгаа нь 498693,9 мянган төгрөгөөр өссөн байгаа нь хиймэл нуур, худаг, цахилгааны шугам шилжүүлэн авсан болоод төсвийн хөрөнгөөр жижиг трактор гэх хөрөнгө тус тус данс бүртгэлд авсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	8507,0	0	-8507,0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	26922,3	395653,6	368731,3
Үндсэн хөрөнгө	217184,4	357501,5	140317,1
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-38740,0	-40587,5	-1847,5
Нийт хөрөнгө	213873,7	712567,6	498747,9
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	213873,7	712567,6	498747,9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	213873,7	712567,6	498747,9

Авлага оны эхэнд 8507,0 мянган төгрөг байсан нь ойн зурвасын хайс хамгаалалтын үнэ урьдчилан шилжсэнтэй холбогдон үүссэн ба тайлант онд мод үржүүлгийн хайс худалдан авч авлага барагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 368731,3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 13693,3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Баянхонгор ОНӨААӨ ТҮГ-аас аймгийн ИТХТ-ийн 2019.01.31-ны 12 тоот тогтоолоор 533747,4 мянган төгрөгөөр

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны 09 дүгээр сарын 19- ны өдрийн 95 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан 51415,5 мянган төгрөгийн хөрөнгө бараа материалд шилжүүлж авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл тайлант онд 140317,1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны 01 дүгээр сарын 31 ны өдрийн 12 дугаар тогтоолын дагуу балансаас баланст шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

Төсвийн хөрөнгөөр 2019 онд 9500,0 мянган төгрөгийн жижиг трактор авсныг үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусган авч нийт 357501,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна.

Биет бус хөрөнгө нь санхүүгийн программ 836,0 мянган төгрөг, газар 72130,8 мянган төгрөгийн өртөгтэй дансанд бүртгэсэн байна.

Өр төлбөр, авлагын дансны үлдэгдэл байхгүй болно.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 712567,6 мянган төгрөг болж өмнөх оноос 498693,9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 498693,9 мянган төгрөгийн нэмэгдсэн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байхгүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 70101 хөтөлбөрт зориулан урсгал үйл ажиллагааны санхүүжилт 70760,0 мянган төгрөгийн санхүүжилт, өөрийн үйл ажиллагааны орлого 190,0 мянган төгрөгийг оруулсан ба гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагаанд 70791,6 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 158,4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн.

Хүснэгт 2. Авсан санхүүжилт, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	70760,0	70601,6	158,4	0,2
Үндсэн үйл ажиллагааны орлого	5000,0	190,0	4810,0	99
Нийт дүн	75760,0	70791,6	4968,4	99,02

Тайлант онд үйл ажиллагааны орлогыг 4810,0 мянган төгрөг дутуу биелүүлсэн нь мод суулгацын нөөц муугаас шалтгаалсан гэж байгаа боловч төлөвлөгөөгөөр батлагдсан 5,0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж чадаагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 34 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 30 эрсдэл тодорхойлж нийт 30 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 659,1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 508,5 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 150,3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 659,1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 508,5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүллээ. Үүнд:

1. Ажиллагсдын цалингаас суутгасан ХХОАТ-ын суутгалыг Татварын хэлтэст шилжүүлэхдээ 508815 төгрөгийг илүү шилжүүлж санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллээс хугацаанд нь 145 мэдээллийг, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Тайлбар
1	Бүтэн жил	11	11	10	1		
2	Хагас жил	4	4	3	1		
3	Улирал бүр	1	4	3	1		
4	Сар бүр	3	36	15	21		
5	Тухай бүр	8	96	96			
	Нийт	27	151	127	24		

2019 оны тайлант онд бүтэн жилээр тавих худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Байгууллагын батлагдсан төсөв гэсэн 3 мэдээлэл хугацаа хоцроосон мөн сар бүр оруулах мэдээллийн Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт оруулах 5,6,7,8 сарын мэдээ, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн 5,7,8 сарын мэдээ, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт тавих мэдээний 7 сарын мэдээг тус тус хугацаа хоцроосон байна.

Хугацаа хоцроосон тайлбарыг нягтлан бодогчоос авахад алдаатай буруу оруулсан мэдээллийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс шалгаж мэдээллийг засуулж оруулснаас хугацаа хоцроосноор бүртгэгдсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Байхгүй

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын нягтлан бодогч ажиллагсдын цалингаас суутгасан 150,3 мянган төгрөгийн НДШ-г цалингийн зардлаар тайлагнаагүй, ажил олгогчоос төлөх НДШ-н зардлаар үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд тайлагнасан.

1.2. Эрсдэл:

Тайлан үнэн зөв гаргах

1.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 388 дугаар тушаалын 3-т зардал, 3.5-т заасны дагуу Төсвийн зардлыг одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомж, сангийн яамнаас гаргасан дансны нэгдсэн жагсаалтын дагуу ангилан бүртгэнэ гэсэн заалтыг цаашид дагаж мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	35,429,355.00	395,653,687.68
35	БАРАА МАТЕРИАЛ	26,922,355.00	395,653,687.68
354	Хангамжийн материал	26,922,355.00	395,653,687.68
35420	Аж ахуйн материал	6,894,355.00	6,894,355.00
35470	Бусад хангамжийн материал	20,028,000.00	388,759,332.68
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	178,444,399.32	316,913,977.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	178,444,399.32	316,913,977.39
392	Биет хөрөнгө	106,313,599.32	244,783,177.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,276,300.00	24,853,386.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-495,186.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	26,398,400.00	35,898,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-25,401,919.88	-26,635,900.01
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,082,453.00	11,082,453.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,582,849.51	-11,652,336.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,023,459.00	1,023,459.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-919,243.29	-968,097.50
39214	Бусад үндсэн хөрөнгө	99,437,000.00	211,677,000.00
393	Биет бус хөрөнгө	72,130,800.00	72,130,800.00
39301	Програм хангамж	836,000.00	836,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-836,000.00	-836,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	72,130,800.00	72,130,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	213,873,754.32	712,567,665.07
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	213,873,754.32	712,567,665.07
51	Засгийн газрын хувь оролцоо	213,873,754.32	712,567,665.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	211,388,886.00	211,388,886.00
51101	Өмч: - төрийн	211,388,886.00	211,388,886.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,096,868.32	500,790,779.07
51210	Өмнөх үеийн үр дүн	2,096,868.32	2,096,868.32
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	498,693,910.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	388,000.00	388,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	213,873,754.32	712,567,665.07

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	60,723,840.00	604,697,418.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,794,900.00	533,937,418.68
120	Нийтлэг татварын бус орлого	1,794,900.00	533,937,418.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,794,900.00	533,937,418.68
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.00	190,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,704,900.00	533,747,418.68
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	58,928,940.00	70,760,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,018,800.00	70,760,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,018,800.00	70,760,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	49,878,320.89	61,359,007.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49,788,320.89	61,359,007.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,764,278.89	61,200,673.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,909,643.00	48,525,326.42
210101	Үндсэн цалин	30,269,102.00	43,533,826.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,640,541.00	1,331,000.00
210104	Урамшуулал	00.00	121,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,539,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,178,388.00	6,154,500.00
210201	Тэтгэврийн даатгал	3,740,445.00	4,185,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	87,588.00	492,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	109,485.00	393,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	21,897.00	98,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	218,973.00	984,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	208,211.00	295,346.00
210301	Гэрэл, цахилгаан	208,211.00	295,346.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,415,656.00	2,801,993.00
210401	Бичиг хэрэг	780,900.00	374,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	2,282,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	134,756.00	145,193.00
2105	Нормативт зардал	00.00	335,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	335,500.00
2107	Томилолт, зочны зардал	573,500.00	155,000.00
210702	Дотоод албан томилолт	573,500.00	155,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	334,439.10	830,000.00

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-162,360.90	396,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	50,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	304,000.00	340,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,800.00	43,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,663,416.79	2,103,007.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	255,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,663,416.79	1,847,507.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,024,042.00	158,334.58
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,238,902.00	158,334.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,238,902.00	158,334.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	10,845,519.11	543,338,410.75
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	229,816.59	44,644,500.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	44,644,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-229,816.59	-44,644,500.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	10,615,702.52	498,693,910.75

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	59,018,940.00	70,950,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90,000.00	190,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	90,000.00	190,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90,000.00	190,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.00	190,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	58,928,940.00	70,760,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,018,800.00	70,760,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,018,800.00	70,760,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	59,018,940.00	70,950,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,018,940.00	70,950,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,994,898.00	70,791,665.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,123,297.00	48,525,326.42
210101	Үндсэн цалин	30,447,232.00	43,533,826.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,676,065.00	1,452,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,539,500.00

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,964,734.00	6,154,500.00
210201	Тэтгэврийн даатгал	3,526,791.00	4,185,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	87,588.00	492,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	109,485.00	393,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	21,897.00	98,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	218,973.00	984,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	208,211.00	295,346.00
210301	Гэрэл, цахилгаан	208,211.00	295,346.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,401,156.00	2,801,993.00
210401	Бичиг хэрэг	766,400.00	374,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	2,282,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	134,756.00	145,193.00
2105	Нормативт зардал	741,000.00	1,229,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	741,000.00	1,229,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	361,200.00	10,800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,300,000.00
210604	Урсгал засвар	361,200.00	9,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	573,500.00	155,000.00
210702	Дотоод албан томилолт	573,500.00	155,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,621,800.00	830,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,125,000.00	396,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	50,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	304,000.00	340,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,800.00	43,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,024,042.00	158,334.58
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,238,902.00	158,334.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,238,902.00	158,334.58

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин нлэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.00	388,000.00	2,096,868.32	213,873,754.32

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн

санхүүгийн тайлангийн аудит

D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.00	388,000.00	2,096,868.32	213,873,754.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,388,886.00	388,000.00	2,096,868.32	213,873,754.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	498,693,910.75	498,693,910.75
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.00	388,000.00	500,790,779.07	712,567,665.07

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/


Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	75,760,000.00	70,791,665.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	75,760,000.00	70,791,665.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	74,760,000.00	70,791,665.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,235,500.00	48,525,326.42
210101	Үндсэн цалин	44,244,000.00	43,533,826.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,452,000.00	1,452,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,539,500.00	3,539,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,109,500.00	6,154,500.00
210201	Тэтгэврийн даатгал	6,140,000.00	4,185,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	492,400.00	492,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	393,900.00	393,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	98,500.00	98,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	984,700.00	984,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	408,000.00	295,346.00
210301	Гэрэл, цахилгаан	408,000.00	295,346.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,008,000.00	2,801,993.00
210401	Бичиг хэрэг	440,000.00	374,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,082,000.00	2,282,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.00	145,193.00
2105	Нормативт зардал	1,230,000.00	1,229,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,230,000.00	1,229,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,800,000.00	10,800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,300,000.00	1,300,000.00
210604	Урсгал засвар	9,500,000.00	9,500,000.00


Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	800,000.00	155,000.00
210702	Дотоод албан томилолт	800,000.00	155,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,169,000.00	830,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	600,000.00	396,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	50,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	340,000.00	340,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,000.00	43,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	75,760,000.00	70,791,665.42
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	70,760,000.00	70,601,665.42
132001	Орон нутгийн төсвөөс	70,760,000.00	70,601,665.42
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	190,000.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	190,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	07.00	07.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00

Аудитын тайланг

Хянан:

Тэргүүлэх аудитор  Б.Мөнхбат 2018.02.15

Аудитын менежер  А.Цээням 2018.02.15

Бэлтгэсэн:

Аудитор  О.Алтансүх 2018.02.15

